



ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠦᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ
2018 ᠣᠨᠢ 3 ᠰᠠᠷᠳ

Дорнод аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2018 оны 3 сард

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД




МОНГОЛЫН СТАТИСТИК



73.3%

26.7%



1124 бүртгэлтэй
ажилгүй иргэд

409 идэвхигүй

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 3 дугаар сарын эцэст 1533 болсны, 1124 (73.3%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 409 (26.7%) нь бүртгэлээ сэргээгээгүй идэвхигүй болон ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд



Өмнөх оны
мөн үе
10.8%




Өмнөх
сараас
27.5%



40.7%

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 423 (69.3%) хүнээр буурч, өмнөх сараас 422 (27.5%) хүнээр өсөж, 1533 болсны 624 (40.7%) нь эмэгтэйчүүд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 55.6 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна.



50 иргэн ажилд зуучлагдан оржээ

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2018 оны эхний 3 сард ажилгүй 1124 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 50 иргэн ажилд зуучлагдан орж, 409 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.



МОНГОЛЫН
УЛСЫН
СТАТИСТИК
ТӨВРӨГ



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 3 сард 5511.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 413.5 (8.1%) сая төгрөгөөр өсжээ.

02

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 3 сард өмнөх оны мөн үеэс 413,5 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 1101.0 (11.5%) сая төгрөгөөр тэтгэмжийн даатгалын сангийн орлого 158.8 (30.0%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

03

Харин нийгмийн даатгалын сангийн зарлага 11342.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1259.8 (12.5%) сая төгрөгөөр өсжээ.

04

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2018 оны эхний 3 сард өмнөх оны мөн үеэс 1259.8 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 158.8 (30.0%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв



ᠮᠤᠩᠭᠡᠯᠡᠳᠡ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠮᠤᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠰᠢᠨᠳᠤᠭᠡᠨ

ЭРҮҮЛ МЭНД



Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 3 сард 478 эх амаржиж, 480 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 27 (5.6%)-аар, амьд төрсөн хүүхэд 23 (4.8%)-аар нэмэгдсэн байна.



1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдэл 2018 оны эхний 3 сард 1 болж, өмнөх оны мөн үеэс 8 хүүхдээр буурч, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 болж өмнөх оны мөн үетэй адил байна.



Хүн амын цэвэр өсөлт 355 болж өмнөх оны мөн үеийнхээс 1.1 хувиар буюу 4-өөр буурлаа. 1000 хүнд ногдох төрөлт 6.1, нас баралт 1.59 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.2 пунктээр, нас баралт 0.32 пунктээр тус тус өссөн байна.



Халдварт өвчнөөр өвчлөгчид 2018 оны эхний 3 сард 595 болж, өмнөх оны мөн үеэс 93 (15.6%)-аар буурсан байна.



Харин цусан суулгаар өвчлөгчид 2 (15.3%)-аар, гахайн хавдраар өвчлөгчид 9 (50%)-аар, халдварт шар өвчнөөр өвчлөгчид 3-аар буурсан байна.



МОНГОЛЫН
ҮНДСЭМ
СТАТИСТИК



ГЭМТ ХЭРЭГ



Аймгийн хэмжээнд 2018 оны эхний 3 сард 207 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 71 (52.2%)-ээр өссөн байна.

Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэрэг өсөхөд хулгайн гэмт хэрэг 81 (39.1%), залилах гэмт хэрэг 8 (3.7%), дээрмийн гэмт хэрэг 1 (0.4%), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 51 (24.6%), хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 3 (1.4%), хөрөнгө завших гэмт хэрэг 3 (1.4%),-өөр өссөн нь голлон нөлөөлөв.



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 оны эхний 3 сард 1009.9 сая төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 112.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 830.4 (5 дахин) сая төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 1.4 (1.2%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.



Нийт гарсан гэмт хэргийн 31 хэргийг 37 хүн согтуугаар үйлдсэн байна. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд 22 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52.7 пунктээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 21 хүн нас барж, 42 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 17 буюу 5 дахин өсч, гэмтсэн хүний тоо 31 буюу 42.4 хувиар буурсан байна.

АЙМГИЙН ТӨСӨВ САНХҮҮ



Аймгийн нэгдсэн төсвийн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 3 сард 15505.1 сая төгрөг, зарлага 12304.7 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 3200.4 сая төгрөгийн ашигтай гарлаа.



Татварын нийт орлого 3759.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 92.5 (29.1%) тэрбум төгрөгөөр буурахад орлогын албан татвар 41.4 (1.7%) сая төгрөг, бусад татвар, төлбөр хураамж 98.0 (3%) сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөллөө.



ᠠᠶᠢᠮᠦᠨ ᠲᠦᠰᠦᠪ ᠰᠠᠨᠬᠤᠭᠤ

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



УИДСОНМ СТАТИСТИК



Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.




Хэрэглээний үнийн индекс 2018 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 4.3 хувиар, өмнөх сараас 0.1 хувь, жилийн эцсээс 1.7 хувиар тус тус өссөн байна. Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.1 хувиар өсөхөд хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.1 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн дүн 0.3 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.



ХӨДӨӨ АЖ АХУЙ



ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, жил бүрийн 3 дугаар сард толгой



Том малын зүй бус хорогдол 2018 оны эхний 3 сард улсын хэмжээнд 1348 болж, өмнөх оны мөн үеэс 2376 (63.8%) толгойгоор буурсан байна.

Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 537, хонь 379, үхэр 350, адуу 81, тэмээ 1 байна.


Нийт хорогдсон малын 39.8 хувийг ямаа, 28.1 хувийг хонь эзэлж байна.

Аймгийн хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2018 оны эхний 3 сард 139 толгой болж, өмнөх оны мөн үеэс 541 (79.5%) буурав.

АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний 3 сард урьдчилсан гүйцэтгэлээр 16.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.7 (4.6%) тэрбум төгрөгөөр өслөө. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны эхний 3 сард 15.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 0.2 тэрбум төгрөгөөр өссөн.



Цахилгаан, дулаан үйлдвэрлэх аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 0.4 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.



ᠠᠵᠢ ᠦᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷ

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах тоглоом



Валютын ханш



аппликейшнаас

**СТАТИСТИКИЙН
МЭДЭЭЛЛЭЭ аваарай**



Data lab

тооллого судалгааны микро мэдээллийн сан



SOCIAL NETWORK



[www.facebook.com/
StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)

ЛАВЛАХ УТАС



1900-1212

ЦАХИМ ШУУДАН



information@nso.mn